



ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ



E-NEWSLETTER

- [f facebook.com/Rtcc.mn0](https://www.facebook.com/Rtcc.mn0)
- [g http://rtcc.mrtd.gov.mn](http://rtcc.mrtd.gov.mn)
- [✉ info@rtcc.mrtd.gov.mn](mailto:info@rtcc.mrtd.gov.mn)
- [☎ +976 77244409](tel:+97677244409)

ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САМБАР

2018 оны 8-р сарын дугаар



Төмөр замын салбарын нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэн ажиллаж байна

Төмөр замын болон хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч байгууллагуудын хоногийн болон сарын статистик мэдээг салбарын мэдээллийн нэгдсэн санд төвлөрүүлж байна. Үүнд:

- Төмөр замын тээвэрлэлтийн мэдээ
- Төмөр замын ашиглалтын ажлын үндсэн үзүүлэлтийн мэдээ /өссөн дүнгээр/
- Ачилтын мэдээ /ачааны төрлөөр, өссөн дүнгээр/
- Дамжин өнгөрөх ачааны мэдээ /чиглэл, зуучлагч, төрлөөр, өссөн дүнгээр/
- Чингэлэг тээвэрлэлтийн мэдээ /чиглэл, зуучлагчаар, өссөн дүнгээр/
- Зорчигч тээвэрлэлтийн мэдээ
- Хөдлөх бүрэлдэхүүний парк ашиглалтын мэдээнүүд багтаж байна.



“British Railway Modelling”, “Railway Magazine”, “Railway Digest” сэтгүүлүүдийн дугаарыг төвийн сайтад байршууллаа

2018 оны наймдугаар сард Train, Railways Illustrated, Garden Railways, British Railway Modelling сэтгүүлийн дугааруудыг харах болон татаж авах форматад хөрвүүлэн төвийн www.rtcc.mrtd.gov.mn цахим хуудсанд байршуулж олон нийтэд хүргэлээ. RailwayDigest сэтгүүлийн 29-р хуудаснаас Олон улсын өндөр хурдны төмөр зам, Railway Magazine 80-р хуудаснаас төмөр замын цэцэрлэгт хүрээлэнгийн тухай мөн “Симс” компанийн сүүлд хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр зэрэг сонирхолтой мэдээ мэдээллийг харах боломжтой.

SIEMENS WINS £1.5BILLION PICCADILLY LINE ORDER

The
RAILWAY
BRITAIN'S BEST-SELLING RAIL TITLE July 2018
Magazine

West Coast Railways' Lake District lifeline

■ £5bn rail investment for Wales
New trains, new identity, electrification and more

■ GBRf buys 16 Class 56s

CLASS 66 - FREIGHT WITHOUT FRONTIERS FRANCO-CROATI LOCOMOTIVES ALTERNATIVE FUELS FOR TRAINS

WORLD'S THIRD OLDEST LOCOMOTIVE DISCOVERED ON TYNESIDE

ON YOUR FREE DVD
PENDON PT. 2, A TRIP TO TMC, INSIDE HATTONS

BRITISH RAILWAY MODELLING

BRM VINTAGE
CLASSIC LAYOUTS & TRUSTED TECHNIQUES
IN 00, 0, 1/32 AND 2FS

ALSO THIS ISSUE

- GRASS, BEFORE IT WAS STATIC
- TRI-ANG RETROSPECTIVE
- BORCHESTER TRACKPLAN SPECIAL
- and more...

REVIEWED: MINERVA FROM MINK, DIGITAL SOUND CONTROLLER 5, DCC SIGNALS, TMC BOLSTER WAGONS

EXCLUSIVE


BRM MEETS DAVE ROWE



Япон улсын “ЖЕТ Коннект” ХК-тай хамтран ажиллах санамж бичиг байгууллаа



Зам, тээврийн хөгжлийн яамны харьяа “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” УТҮГ-ын захирал Т.Ариунбаатар, Япон улсын “ЖЕТ Коннект” ХК-ийн захирал Эики Шигета нар хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурлаа.



Тус санамж бичигт тодорхой цэгүүд дэх хөдлөх бүрэлдэхүүнийг удирдан зохицуулах системийг хөгжүүлэх; Монгол улсын галт тэрэгний хөдөлгөөн удирдлага, зохицуулалтыг хөгжүүлэх, судалгаа хийх; төмөр замын тээвэрлэлтийн ашиг орлогыг нэмэгдүүлэхэд шинэ технологи нэвтрүүлэх замаар дэмжлэг үзүүлэх; техникийн хамтын ажиллагааны хүрээнд түншлэлийг бий болгох; Япон улсын холбогдох байгууллага, компаниудтай хамтран ажиллах чиглэлээр холбоо тогтоож, дэмжлэг үзүүлэх зэрэг төлөвлөгөөнүүд тусгагдсан байна.

Санамж бичиг байгуулагдсанаар систем хөгжүүлэлтийн чиглэлээр “ЖЕТ Коннект” ХК нь “ГТХЗНТ” УТҮГ-ыг Япон улсын туршлага дээр сууринласан системээр, галт тэрэгний хөдөлгөөн удирдлагын хүрээнд техникийн туслалцаа, зөвлөгөөгөөр хангах, Япон улсын төмөр замын оператор компаниудтай зөвлөлдөж тэдний туршлага дээр үндэслэн төвийн инженер, албан хаагчдыг сургаж ажиллах юм.



Төмөр замын ачааны вагоны дугаарлалтад тавих шаардлагын хүрээнд МНС 6630-2:2016” стандартыг үндэслэн төмөр замын хөдлөх бүрэлдэхүүнд дугаар олгох, бүртгэх чиг үүргийг хэрэгжүүлж “Төмөр замын зураг төслийн институт” ХХК-ийн 47 хөдлөх бүрэлдэхүүнд шинээр 8 оронд дугаар олголоо. Мөн татах хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтад тавих шаардлагын дагуу МНС 6630-3:2016 стандартыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, дугаарлалтыг шинэчлэх ажлын хүрээнд “Мөнгөн хөдөлгүүр” ХХК, “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “МТЗ” ТӨХК “Багануур” ХХК, “Эрдэнэт ДЦС” ХХК, “Хөтөлийн цемент шохой” ХК, “Шарын гол” ХК-ийн эзэмшилийн 23 зүтгүүрт шинээр дугаар олгосон байна.



“ММЗИХ” ТББ-аас зохион байгуулсан төмөр замын тээврийн салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг горилох сургалтад 2018 оны 1 ба 3 дугаар сард хамрагдсан инженеруудийн шалгалтын дүнг орон тооны бус зөвлөлөөс хэлэлцэн гарсан шийдвэрийн дагуу материалуудыг бүрдүүлж Зам, тээвэр хөгжлийн дэд сайдад 2018 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн 124 тоот албан бичгээр асуудлыг шийдвэрлүүлэхээр хүргүүллээ.



Төмөр замын салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох дүрмийг шинэчлэх төсөл боловсруулж байна.



Төмөр замын мэдээллийн сүлжээнд холбогдох ажлын хүрээнд “МТЗ” ТӨХК, “БТЕГ” ХХК-ний хөдлөх бүрэлдэхүүн хөдөлгөөн зохицуулалтын хэлтэстэй хэлэлцэн тээвэрлэлт, осол гологдол болон холбогдох бусад мэдээллийг төвийн файл шэйринг owncloud/ програм хангамжид нэгтгэн байршуулахаар нэвтрэх эрх нээж, мэдээлэл байршуулах байршуулах талбарыг үүсгэн ажиллалаа.



Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу бэлтгэсэн Төмөр замын тээврийн тухай хуулийн талаарх асуулгын хариуг албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүллээ.

КОЙКА олон улсын байгууллагын төсөлд хамруулахаар төвийн ТЭЗҮ болон зөвлөх үйлчилгээ, төвийн барилга барих, тоног төхөөрөмж суурилуулах төслийн материалыг ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ-ын мэргэжилтэнд цахимаар хүргүүлсэн.





2018 оны 08 дугаар сарын 28-31-ны хооронд ЗТХЯ-ны холбогдох мэргэжилтний төмөр замын тээврийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн мэдээллийн нэгдсэн санг баяжуулалт хийж ажиллалаа.

Мэдээ, мэдээлэл

Зорчигч тээвэрлэлт 2018 оны долдугаар сард 245 млн. зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 1.6 %-иар өссөн, ачаа тээвэрлэлт нь 2018 оны долдугаар сард 10672,50 млн.тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 18,1 %-иар өссөн үзүүлэлттэй байна.



ИНФОГРАФИК



Мэдээ, мэдээлэл



Суурь бүтцийн 2018 оны 8-р сарын хөдөлгөөний зурмагийн тасалдлын тайлан

2018 оны 8-р сард нийт 225 тасалдал, 360 галт тэрэг цагийн барилт үүсч, 71,25 сая төгрөгийн хохирол гарсан байна.

Өмнөх сарын тасалдлын тоо, галт тэрэгний цагийн барилт, хохирлын хэмжээтэй харьцуулахад:

Тасалдлаас үүссэн хохирол, сая төг




Тасалдлаас үүссэн хохирол, сая төг



Зурмагийн тасалдлын хэмжээ өмнөх сараас 1 нэгж буюу 0,4%-иар буурсан ч 81,6-н цаг буюу 29,3%-иар, хохирлын хэмжээ 23,83 сая төгрөг буюу 50,2%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Зурмагийн тасалдлын тоо болон тасалдлаас үүссэн хохирлын шалтгааныг үзэхэд:



Мэдээ, мэдээлэл



Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 169 дүгээр тушаалыг хэрэгжүүлж, “ГТХЗНТ” УТҮГ-ын захирлын 2018.08.05-ны өдрийн А/49 дүгээр тушаалаар төвийн 2018-2019 оны өвөлжилтийн бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөө болон ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж хэрэгжүүлж ажиллаж байна.

“ГТХЗНТ” УТҮГ-ын захирлын 2018.08.17-ны өдрийн А/50 дугаар тушаалаар “Багануур” ХК, “Мөнгөн хөдөлгүүр” ХХК, “Шарын гол” ХК, “Монголросцветмет” ХХК-д “10”, “11”, “12”, “13” тоот өмчлөгчийн кодыг олгож олон нийтэд мэдээллээ.

МУ-ын ЗГ-ийн 2018.08.22-ны өдрийн “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоолыг ажилтнуудад танилцуулан, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж ажиллаж байна.

Төвийн ажилчдын дунд “Хүний нөөцийн мэргэжилтний гэрээ байгуулах нь” сэдэвт сургалт зохион байгуулагдлаа.





 8-р давхар, Хан-Уул цамхаг,
Б.Шаравын гудамж 6,
З-р хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот 17042, Монгол Улс

